

**“Монинжбар” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит бус хурлын тэмдэглэл**

2018 оны 10 – р сарын 05

Хурал эхэлсэн цаг 15:30

Хурлаар хэлэлцэх асуудлууд

1. 2018 оны эхний хагас жилийн компанийн үйл ажиллагааны тайлан
2. Компанийн хэтийн зорилт, 2019 оны төлөвлөгөө
3. ТУЗ – ийн гишүүдийг баталгаажуулах
4. Компанийн нэр өөрчлөх

Хурлын явц:

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Цогтгэрэл: Тооллогын комиссоос хурлын ирцийг авч, хурлаа бүх гишүүдийн 75% -ийн ирцтэйгээр эхлүүлэх болсоныг мэдэгдэж, компанийн дүрмийн дагуу хурлын дарга, тэргүүлэгчдийг сонгох санал гаргав.

Гишүүд санал нэгтгэйгээр Б.Цогтгэрэлээр хурал даргалуулах санал өгөв.

Хурлын дарга: Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж, батлуулсаны дараа хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгтэй холбоотой санал өгөх гишүүд **Байхгүй** тул хурлын дэгийг батлав.

- Б.Цогтгэрэл: - Тооллогын комиссыг /даргаар/ Б.Батбаатар, гишүүнээр ТУЗ – ийн нарийн бичиг Н.Энхчулуун нарын бүрэлдэхүүнтэй байгуулахаар хурал зохион байгуулах комиссоос оруулж байна. Батлах уу. Та бүхэнд ямар санал байна. Гишүүдэд санал хүсэлт байхгүй, саналыг зөвшөөрсөн тул Тооллогын комиссыг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж батлав.

Тооллогын комиссын дарга Б.Батбаатар, Н.Энхчулуун нар ирцийг бүртгэхэд нийт саналын эрхтэй 15 869 233 ширхэг хувьцааны 12 047 947 ширхэг хувьцааны эзэмшигчид хуралдаа ирсэн ба 75,92 хувийн ирцтэй байлаа. /Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав./

Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо
Ш.Алтанцэцэг	77 831
Б.Осолгүйгэрэл	30 000
С.Баярцэцэг	6 000
Б.Цогтгэрэл	3 548 345
Ц.Чингүүнболд	1 824 000
Ц.Оргилболд	912 000
Б.Нарантуяа	50 000
Б.Баярсайхан	354 477
Б.Ариунжаргал	20 000
С.Мягмарсүрэн	35
Ж.Энхтунгалаг	10
Би Ди Сек ҮЦК ХК	5 225 306
Нийт	12 047 947,00
Санал авсан хувь	75,92

Б.Цогтгэрэл:

Сайн байцгаана уу. Та бүхнийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралдаа хүрэлцэн ирсэн талархал илэрхийлье.

Хурлын дэгийн дагуу 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, 2019 оны зорилт, төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа танилцуулна.

Б.Нарантуяа: - Миний хувьд ажил аваад удаагүй байна. Энэ оны 8 – р сарын 07-ны өдрийн ТУЗ – ийн 15 тоот тогтоолоор Монинжбар ХК – ийн Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2019 оны эхний 9 сарын үйл ажиллагааны тайланг та

бүхэнд танилцуулж байна. Та бүхний гар дээр цахим болон хэвлэмэлээр очсон байгаа. /Тайланг хавсаргав/

Ажиллах хугацаандаа компани бол эрхзүйн бичиг баримт нь туйлын хангалтгүй байсан тул дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

- Компанийн дотоод журам,
- Компанийн хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн журам,
- Ажлын хувцасны журмуудыг боловсруулан мөрдөж ажлуулаад байна. Мөн

Компанийн үргүй зардлуудыг бууруулах үүднээс

- Мобиком болон суурин утасны зардлуудыг бууруулах хүрээнд өндөр төлбөр гарч байсан дугааруудыг хувь хүний нэр лүү шилжүүлж, суурин ашиглагдахгүй байгаа дугааруудыг хаасан,
- Нийгмийн даатгалын тайланд тусгагдсан ажилладаггүй хэрнээ нийгмийн даатгал төлж байсан инженер техникийн хүмүүсийг холбогдох хууль журмын дагуу чөлөөлсөн байгаа.
- Цалин олгогдохгүй олон сар явсныг ямар ч байсан энэ сараас олгож эхлээд байна

Инженер техникийн ажилтны хувьд залуу халаа, хүний нөөцийн бодлогоо илүү сайн болгож, мэргэжилтэй ажилтан бэлтгэх авах шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд энэ чиглэлийн мэргэжлийн сургалтыг өөрсдийн нөөц боломж болон үйлдвэрлэлийн бааздаа түшиглэн зохих дүрэм, журмын дагуу зохион байгуулъя гээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас сургалтын зөвшөөрлийг авахаар баримт бичгийн бүрдүүлэлтийг хийж байна.

Гүйцэтгэх захирлын илтгэлийг хавсаргав.

ТУЗ – ийн дарга Б.Цогтгэрэлийн илтгэл

- Компани сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулаагүй, алдагдалтай, оршин тогтнох уу үгүй юу гэдэг дээр байна. 2018 оны 6 – р сарын 28 – аас 7 – р сарын 05- ны өдрүүдэд компанийн хувьцаа эзэмшигчид бид ер хөндлөнгийн нүдээр харвал ямар байна вэ гэсэн Хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр Хөндлөнгийн хяналтыг ТУЗ – ийн тогтоолоор ажиллуулсан.

Энэ ажлын дүгнэлтээр “Компанийн ирээдүй бүрхэг байна”, мөн компанийн үйл ажиллагаа, удирдлага, менежмент болон санхүүгийн хувьд маш тааруу үзүүлэлттэй гарсан тул бид менежментийн шинэчлэл хийж, компанийн үйл ажиллагааг сэргээе гэсний дүнд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж шинэ гүйцэтгэх удирдлага томилсон. Ер нь компани унах болсон шалтгаан:

- Төрийн худалдан авах үйл ажиллагаанд түшиглэсэн. Энэ нь ганц компанийн буруу биш Төрийн худалдан авах ажиллагааны алдагдалтай холбоотой. Манай компани бол инженерийн шугам сүлжээний угсралт, суурьлуулалт, шинэчлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг ууган компаниудын нэг. Гэтэл энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг маш олон жижиг компаниуд бий болсон. Төрийн худалдан авах ажиллагаа “Хамгийн сайн тендер” гэдэг нь “Хамгийн бага үнийн санал” гэсэн зарчмыг баримталж худалдан авах ажиллагааг явуулж байгаа нь энэ ажлын үнэ цэнэ, өртөгийг маш доогуур оруулж тендерт ямар ч мэргэжлийн судалгаа шинжилгээгүй, хамгийн бага үнийг тавьж шалгаруулалтад ялж байгаа нь томоохон бүтэцтэй, тогтмол зардал ихтэй компаниудыг унагаж ирсэн байна
- Зөвхөн дулааны улиралд л ажилладаг, ингэснээр хүйтний улиралд зарлага нь орлогоо иддэг
- Ажил багатай байснаас инженерүүд нь өөр компанид туслан гүйцэтгэгчээр ажиллаж, улмаар компаниасаа холдох, хувиараа ижил үйл ажиллагаа явуулах эрх авч компанийн ажлыг хувиараа хийх, туслан гүйцэтгэгчээр ажиллуулсан нь бас алдагдал хүлээх байдалд хүргэсэн.
- Инженер, техникийн ажилчид ажил гүйцэтгэхдээ бүх томоохон зардал, зээлийн үйлчилгээ зэргийг компани хариуцаж, үр ашгийн тооцоо, техник ашиглалтад хяналтгүй, харилцан тооцоогүй явж ирсэн нь компанийг ихээхэн алдагдалд оруулжээ

Миний хувьд энэ компанийн томоохон хувьцаа эзэмшигч. Компанийн үйл ажиллагааг хөндлөнгөөс харж явсан нь бас алдаа болж. Сүүлдээ бүр хувьцаагаа зарах уу гэдэг асуултад хүртэл тулгарсан. Гэхдээ компанид бодлогын хүрээнд ойртоод ажиллаад, судлаад үзэхэд бас тийм алхах газаргүй, хөгжих боломжгүй болсон биш салбарын хувьд харин ч хийх ажил ихтэй байна.

Улаанбаатар хот нь социализмийн үед баригдсан инженерийн шугам сүлжээний сүүлийн потенциалийг л ашиглаж барилга байгууламж барьж байна. Дэд бүтцийн хөгжил, хүн амын өсөлт, автомашины тооны өсөлт, барилгажилтаасаа даруй 15 жилээр хоцрогдож байна. Төрийн үйл ажиллагааны буруу тогтолцоо буюу газар олголтыг түрүүлж хийсэн нь дэд бүтцийн системийг өргөтгөхөд маш том хүндрэл, саад болж байна. Цогц шийдлээр бус хэсэгчлэн бүтээн байгуулалтыг хийж байгаа нь газар доорх бүтээн байгуулалт хийх боломжгүйд хүрч байна.

Харин бид дэд бүтцийн ажлыг урьдчилан хийгээд дараа нь газраа олгодог, барилгаа барьдаг байа гэсэн зөв бүтцийг шат шатны удирдах байгууллага, төр, Улсын их хурлын чуулганд оруулахаар ажиллаж байна.

Энэ салбарын бүтээн байгуулалтыг хийх маш их боломж байна. Иймд бид цааш ажиллах шаардлагатай. Жишээлбэл: Шинэ нисэхийн бүтээн байгуулалттай холбоотой тэр хавьд 100 000 оршин суугч бүхий дагуул хотыг бий болгох төсөл байна. Энэ хотыг газар олгохоосоо өмнө инженерийн шугам сүлжээ, цэвэр, бохир ус нь бий болсны дараа газар олголтыг хийж дараа, дараагийн бүтээн байгуулалтын ажлууд үргэлжлэх ёстой юм. Эрүүл газар хаана байна тэнд хамгийн түрүүнд энэ шугам сүлжээний ажил хийгдэж байж гэмээн хот суурин бий болох жишээтэй.

Ингээд явахад бид жилд 10 гаруй сая ам.долларын ажил хийх боломж байна гэж үзэж байгаа.

Дэд бүтэц бол улсын онцгой объектод ордог. Маш өргөн газар нутгийг хамарч хийгддэг бүтээн байгуулалт юм. Бид бууралтаар биш арай өөдрөгөөр харж байна.

“Би Ди Сек ҮЦК” ХК – нь 2018 оны 7 – р сарын 09 – ны өдрөөс эхлэн манай томоохон хувьцаа эзэмшигч болсон байгаа. Тэр хэрээрээ ч манай ТҮЗ – д ажиллаж эхэлсэн. Мөн надтай адил энэ компанийн ирээдүйг өөдрөгөөр харж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

Хэлэлцэх асуудлын 2 – 2019 оны зорилт, төлөвлөгөө.

Б.Нарантуяа – Энэ жил бид “Н ЭЙ БИ” ХХК–тай түншлэл болон Европын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр хэрэгжиж буй WSNR17B дугаар бүхий “Улаанбаатар хотын Тасганы усан сангаас 3, 4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метр урттай Ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил”-ыг гүйцэтгэж байна. Энэ ажилд одоогийн байдлаар 1 бригадтай ажиллаж байна. Ирэх оноос 2 бригадтай ажиллах тул туслах ажилтан, инженерүүдийг нэмнэ. /зорилт, төлөвлөгөөг хавсаргав. /

2019 оны удирдлагын болон үйл ажиллагааны зардлын төслийг та бүхэнд харж байгаа байх. Та бүхэнд асуух зүйл байна уу?

С.Мягмарсүрэн: - Энэ түлшний зардал ийм бага гарах уу?

Б.Нарантуяа- Түлш бол маш өндөр гарахаар байна. Мөн энэ нь ашиглалтад гарах зардал юм. Энд арай багаар тооцоолсон байгаа. Хүнд машин механизм, цахилгаан үүсгэгч гээд бүх тоног төхөөрөмж маань түлш зарцуулдаг. Төсөл бүрийн шатахууны зардал төсөвтөө суудаг учир энд бүгдийг хамруулаагүй.

Б.Цогтгэрэл: - За тэгвэл санхүүгийн төлөвлөгөөндөө энэ зардлын тооцооллыг нэмж гаргах үүрэг өгөх үү?

Б.Нарантуяа: - Бодит зардлыг Авто баазын дарга маань өгөх байх. Мөн бид ирэх онд 10 орчим тэрбум төгрөгийн ажил хийнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Үүнээс дор хаяж 8-10% - ийн ашигтай ажиллана гэсэн төлөвлөгөөтэй байна.

Б.Цогтгэрэл: - Хуванцар болон дулаалгатай хоолойн үйлдвэрийн төсөл гэсэн байна. Үүнийг тодруулбал?

Б.Нарантуяа: - Энэ ТЭЗҮ – нь хийгдчихсэн. Манай компанийн үйлдвэрлэлийн баазад хийгдэх боломжтой төсөл байгаа юм. Бидэнд нөөц бололцоо, үйлдвэрлэл явуулах газар нь байна. Иймд энийг ажил болгоё, эхлүүлье гэж бодсон байгаа.

С.Мягмарсүрэн: - Танай хуучин Хархорин захын урд талд байдаг хангамжийн бааз байгаа юу?

Б.Нарантуяа: - Байгаа. Гэхдээ бид яг тэр газрынхаа хойно 3га газрыг өөрийн эзэмшилдээ авчихсан байгаа. Энэ газраа бид үйлдвэрлэлийн болон сургалтын бааз болгон ашиглахаар төлөвлөж байна. Манай хуучин газар маань Хуучин Хадгаламж банкны өрөнд харилцан суутгаж, Монгол Базальт ХК – д оччихсон байдаг. Бид энэ талаар холбогдох бүх материалыг шалгаж тодруулж үзсэн байгаа.

Гэхдээ балансаас хасагдаагүй байгаа юм билээ. Бас харилцан тооцоо үүсэхээр юм билээ. Хуульчдаар судлуулж байгаа.

Манай компани Тасганы усан сангаас Москва хорооллын усан хүртэл 7054м газар цэвэр усны төв шугамын Ф600мм – ийн РЕ хуванцар хоолойн угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

Б.Нарантуяа: - Мөн бид компанийн одоо байгаа төв байрыг шинэчлэн 16 давхар үйлчилгээ, орон сууцны зориулалт бүхий барилга байгууламж барихаар зураг төсөл болон холбогдох зөвшөөрөл, баримт бичгийн бүрдүүлэлтийг хийлгэсэн байгаа. Ирэх хавартаа багтаан ажлаа эхлүүлэх зорилготой байгаа. Энэ асуудалд ТУЗ-ийн гишүүд маань анхаарч, дэмжиж ажиллана гэдэгт найдлага тавьж байгаа.

Б.Цогтгэрэл: Хурлаар хэлэлцэх асуудлыг дүгнээд ярилцаад батлаад явдаг. Тийм болохоор бүгдээрээ 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан болон 2019 оны зорилт, төлөвлөгөөг Хангалттай гэж үзээд батлах уу? Та бүхэн ямар саналтай байна?

Гишүүд санал нэгтэй байна. Татгалзах зүйлгүй, Зөвшөөрч байна.

Хэлэлцэх асуудлыг 3 – ТУЗ – ийн гишүүдийг баталгаажуулах

Б.Цогтгэрэл: - 2018 онд нэлээд хэдэн гишүүд өөрийн саналаар ТУЗ – ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн. Мөн шинэ хувьцаа эзэмшигч орж ирсэнтэй холбоотой орны гишүүдийн түр томилгоо ТУЗ – ийн хурлын тогтоолоор гарсан байгаа. Иймд бид компанийн тухай хуулийн 77.3-д зааснаар өмнөх гишүүдийг чөлөөлж, дараагийн ТУЗ – ийн гишүүдийг томилох ёстой байгаа. Үүний хүрээнд ТУЗ – ийн гишүүнээр сонгогдох хүсэлтээ ирүүлсэн болон ТУЗ – өөр түр гишүүнд томилсон материалуудтай танилцсан байх. Дээрх гишүүдэд саналаа куммулятив аргаар тооцоод өгөөд явчих байх. /Танилцуулга болон хүсэлт, ТУЗ – ийн тогтоолын хуулбарыг хавсаргав/

Хэлэлцэх асуудлыг 4 – Компанийн нэрийг өөрчлөх

Б.Цогтгэрэл – Бид Монинжбар ХК гэдэг нэршлийг Монголын инженерийн барилга гэсэн бүтэн нэршлээр болгоё гэж бодож Хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцэх асуудлаар оруулж ирсэн. Компанийн төлөөлөн зөвлөлийн гишүүд БиДиСек ҮЦК ХК – ийн төлөөлөл энэ нэршлээрээ байлгах саналтай байгаа гэдгээ илэрхийлсэн тул энэ асуудлыг өнөөдрийн энэ ээлжит бус хурлаар хэлэлцэхээс түдгэлзүүлээд буцаан татаж байна. Иймд энэ асуудлыг хэлэлцэх шаардлагагүй гэж үзлээ.

Шийдвэрлэсэн нь:

- Компанийн 2018 оны эхний 9 сарын үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж үзэж хүлээн авсан тогтоол гаргах,
- 2019 оны зорилт, төлөвлөгөөг батлах
- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Ердийн гишүүн
- Б.Цогтгэрэл, Б.Нарантуяа, Б.Баярсайхан, С.Баярцэцэг, Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж Хараат бус гишүүн
- Л.Батсайхан, Х.Батхишиг, Б.Пүрэв-Очир гэсэн 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр батласан тогтоолыг гаргах

Хурал дууссан цаг: 18:30

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Хурал зохион байгуулах комиссын нарийн бичиг



Н.Энхчулуун

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Хурлын дарга



Б.Цогтгэрэл

[illegible]

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн санал тоолох хуудас

Компанийн нэр: "Монинжбар" ХК
Хувьцааны тоо: 15 869 233,00

	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо	Кумулятив саналын тоо	Хараат гишүүнд өгөх тоо	Хараат бус гишүүнд өгөх тоо	Өгч буй			
						Б.Цогтгэрэл	Д.Даянбилгүүн	Б.Лхагвадорж	Ердийн
1	Ш.Алтанцэцэг	77 831	700 479,00	466 986,00	233 493,00	77 831,00	77 831,00	77 831,00	
2	Б.Осолгүйгэрэл	30 000	270 000,00	180 000,00	90 000,00	45 000,00			
3	С.Баярцэцэг	6 000	54 000,00	36 000,00	18 000,00	6 000,00	6 000,00	6 000,00	
4	Б.Цогтгэрэл	3 548 345	31 935 105,00	21 290 070,00	10 645 035,00	5 322 517,00			
5	Ц.Чингүүнболд	1 824 000	16 416 000,00	10 944 000,00	5 472 000,00	2 736 000,00			
6	Ц.Оргилболд	912 000	8 208 000,00	5 472 000,00	2 736 000,00	1 368 000,00			
7	Б.Нарангуяа	50 000	450 000,00	300 000,00	150 000,00	75 000,00			
8	Б.Баярсайхан	354 477	3 190 293,00	2 126 862,00	1 063 431,00	531 715,00			
9	Б.Ариунжаргал	20 000	180 000,00	120 000,00	60 000,00	30 000,00			
10	С.Мягмарсүрэн	35	315,00	210,00	105,00	35,00	35,00	35,00	35,00
11	Ж.Энхтунгалаг	10	90,00	60,00	30,00	10,00	10,00	10,00	10,00
12	Би Ди Сек ҮЦК ХК	5 225 306	47 027 754,00	31 351 836,00	15 675 918,00		15 675 918,00	15 675 918,00	
13			-	-	-				
	Нийт	12 048 004,00	108 432 036,00	72 288 024,00	36 144 012,00	10 192 108,00	15 759 794,00	15 759 794,00	14,53%
	Санал авсан хувь	75,92				9,40%	14,53%		14,53%

Тооцооллыг гаргасан:

ТУЗ - ийн нарийн бичиг

Н.Энхчулуун

4 санал гишүүд				Тулган батлах дүн	Өгч буй санал			Тулган батлах дүн
					Хараат бус гишүүд			
Б.Баярсайхан	С.Баярцэцэг	Б.Нарантуяа			Х.Батхишиг	Б.Пүрэв-Очир	Л.Батсайхан	
77 831,00	77 831,00	77 831,00	77 831,00	466 986,00	77 831,00	77 831,00	233 493,00	
45 000,00	45 000,00	45 000,00	45 000,00	180 000,00		45 000,00	90 000,00	
6 000,00	6 000,00	6 000,00	6 000,00	36 000,00	6 000,00	6 000,00	18 000,00	
5 322 517,00	5 322 517,00	5 322 517,00	5 322 517,00	21 290 068,00		5 322 517,00	10 645 034,00	
2 736 000,00	2 736 000,00	2 736 000,00	2 736 000,00	10 944 000,00		2 736 000,00	5 472 000,00	
1 368 000,00	1368000	1368000	1368000	5 472 000,00		1 368 000,00	2 736 000,00	
75 000,00	75000	75000	75000	300 000,00		75 000,00	150 000,00	
531 715,00	531 715,00	531 715,00	531 715,00	2 126 860,00		531 715,00	1 063 430,00	
30 000,00	30 000,00	30 000,00	30 000,00	120 000,00		30 000,00	60 000,00	
35,00	35,00	35,00	35,00	210,00	35,00	35,00	105,00	
10,00	10,00	10,00	10,00	60,00	10,00	10,00	30,00	
				31 351 836,00	15 675 918,00			15 675 918,00
				-			-	
10 192 108,00	10 192 108,00	10 192 108,00	10 192 108,00	72 288 020,00	15 759 794,00	10 192 108,00	10 192 108,00	36 144 010,00
9,40%	9,40%	9,40%	9,40%	47,87%	14,53%	9,40%	9,40%	33,33%